

COAL MINING

COKING COAL

LOOSE COKING

ENERGY COAL



TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY

TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY

TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY

ЖИЛИЙН ТАЙЛАН 2023

SINCE 1966



АГУУЛГА

1

Салбарын мэдээлэл

Монгол улсын уул уурхайн салбарын мэдээлэл
Дэлхийн нүүрсний зах зээлийн мэдээлэл

2

Компанийн мэдээлэл

Компанийн мэдээлэл
Бүтэц зохион байгуулалт
Үндсэн үйлдвэрлэл
Эдийн засгийн үзүүлэлтүүд
Санхүүгийн үзүүлэлтүүд
Худалдан авалт, хөрөнгө оруулалт
Тээвэр, логистикийн мэдээлэл
Дотоод хяналтын мэдээлэл

3

Биржийн арилжааны мэдээлэл

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн
тухай хуулийн хэрэгжилт

4

Хувьцааны мэдээлэл

Хувьцаа, ногдол ашгийн хуваарилалт

5

ХАБЭАБО-ны мэдээлэл

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн
Байгаль орчны чиглэлээр
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд

6

Нийгмийн хариуцлага

Нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа

7

2023 оны онцлох үйл явдал

2023 оны онцлох үйл явдалууд

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ



Монгол улс 2023 оны төсвийн тодотголоор гадаад зах зээлд 50 сая.тн нүүрс экспортлох зорилт дэвшүүлж, жилийн эцсийн байдлаар 69.6 сая.тн нүүрс экспортолсон нь бүх цаг үеийн түүхэн дээд амжилт болсон бөгөөд дэвшүүлсэн зорилтоо 39.2%-иар давуулан биелүүлсэн байна.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 7,679.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,072.9 тэрбум төгрөг буюу 66.7 хувиар өссөн байна. Уул уурхайн салбарын хувьд улсын нэгдсэн төсвийн орлогын 29.9%-ийг бүрдүүлсэн бөгөөд нүүрс олборлогчдын хувьд уул уурхайн салбарын орлогын 56.2%-ийг дангаараа бүрдүүлж ажилласан байна.


2023 онд 8,898.1 сая ам.долларын 69.6 сая.тн нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2,394.9 сая ам.доллар буюу 36.8 хувиар, биет хэмжээгээр 37,8 сая.тн буюу 2.2 дахин тус тус өссөн байна. Чулуун нүүрсний 99.3 хувийг БНХАУ руу экспортолсон байна.





Дэлхийн нүүрсний хамгийн том олборлогч БНХАУ-ын нүүрсний олборлолт 2023 онд 4.7 тэрбум тонн болж өмнөх оноос 2.9 хувиар өсөж дэлхийн нийт нүүрс олборлолтын 50.9%-ийг бүрдүүлсэн байна. Харин манай улс дэлхийн нийт нүүрс олборлолтын 0.5%-ийг эзэлж байна.

НҮҮРСНИЙ ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ 2022-2023 ОН



ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ




КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 450 дугаар тогтоолоор 6 сарын хугацаатай онцгой дэглэм тогтоож Бүрэн эрхт төлөөлөгч томилогдон ажиллалаа. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрээр Онцгой дэглэмийг цуцалж, компанийн үйл ажиллагаа хэвийн горимд шилжив.

2022 оны ТҮЗ-ийн 12-р сарын 26-ны өдрийн 25 дугаар тогтоолоор компанийн бүтэц, зохион зохион байгуулалтыг өөрчлөн баталж нийт 407 орон тоотойгоор, 3 сая тонн нүүрс олборлохоор 2023 оны Бизнес төлөвлөгөөг батлан ажиллалаа.






ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ



2023 оны
тэсэлгээ, хөрс
хуулалт, нүүрс
олборлолтын
гүйцэтгэл

ТӨРӨЛ	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн %
Нүүрс олборлолт	мян.тн	3,000.0	3,573.3	119.1%
Хөрс хуулалт	мян.тн	27,000.0	15,352.8	56.9%
Уулын цул	мян.тн	29,142.9	17,905.2	61.4%
Тэсэлгээ	м.куб	-	15.3	-%
Хөрс хуулалт коэффициент	-	9.0	4.3	47.7%





Ордын нөөцийг хаягдал, бохирдол багатай, эдийн засгийн үр ашигтай, бүрэн ашиглахад чиглэсэн уурхайн дунд болон богино хугацааны иж бүрэн төлөвлөлт хийсэн бөгөөд цаашид уурхайн нэгдсэн ТЭЗҮ болон урт хугацааны төлөвлөлт боловсруулах зорилгын хүрээнд нүүрсний нөөцийн тооцоог нарийвчлан хийж, 3 хэмжээст нөөцийн блок модель үүсгэж, ордын хэмжээнд нүүрсний чанарыг бодитоор үнэлэх ач холбогдол бүхий нарийвчилсан хайгуулын ажлыг хийж гүйцэтгэв.



Уурхайн олборлолтын ил тод байдлыг хангах үүднээс 2 сар тутамд хөндлөнгийн маркшейдерийн хэмжилт хийлгэж, улирал, сар, 7 хоногоор төлөвлөгөө, тайлан гарган ажилладаг болсон. Ингэснээр уулын ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөний дагуу хянах хяналт сайжирч, түүхчилсэн дата архив бүрдэх ач холбогдолтой.



Уурхайн өгсүүр замын налууг стандартын дагуу намсгаж, уурхайн орц гарц болон хөрс тээврийн замыг шинээр төлөвлөж нэмэлтээр уурхайн 3 дагч үндсэн гарцыг нээж, хөрс тээврийн нэмэлт зам гаргаснаар замын нэвтрүүлэх чадварыг 2 дахин нэмэгдүүлж үйлдвэрлэлийн осол аваараас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд ажил гүйцэтгэх 48 журам шинээр баталсан.



Гаалийн хяналтын бүсийн зориулалтаар ашиглах 60 га талбайг бүрэн ашиглалтад оруулж, тус талбайд Уурхай дахь засварын газар, оффис, лабораторийн зориулалттай барилгын ажлыг 2023.11 дуусгаж, ашиглалтад хүлээн авсан.

Нүүрс худалдан авагч аж ахуйн нэгжүүд өөрийн техникээр уурхайн мөргөгчөөс экспортын нүүрс ачилт хийдэг байсан тогтолцоог халж, уурхайн гаалийн хяналтын талбайд чанараар нь ангилан овоолго үүсгэн гадаад тээвэрлэлт хийж байна.




Хөрс хуулалт, олборлолтын ажлыг шууд гэрээгээр гүйцэтгүүлж байсныг хуульд нийцүүлэн 2 багцаар нээлттэй тендер зарлаж шалгарсан "Новел Лизинг" ХХК болон "Кэй Ай Рентал Сервис" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.



"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2021 оны шинэчлэгдсэн ТЭЗҮ-с хамаарч уурхайн хөрсний овоолгын талбай, нүүрс экспортлох тээврийн замгүй болох эрсдэл үүссэнийг цаг алдалгүй хоёр уурхайн хамтарсан ажлын хэсгийн хүрээнд асуудлыг шийдвэрлэн, нүүрс тээврийн 9.2 км шороон замыг туслан гүйцэтгэгч компаниудын техник, хүн хүчээр гүйцэтгүүлж 1.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НҮҮРС БОРЛУУЛАЛТ

/сая.тн/




ЦЭВЭР АШИГ

/тэрбум төгрөг/




НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

/тэрбум төгрөг/




НИЙТ ОРЛОГО

/тэрбум төгрөг/



ТАТВАР ТӨЛӨЛТ

/тэрбум төгрөг/





НҮҮРС БОРЛУУЛАЛТ



3.1 САЯ
ТОНН

Үүнээс:
ЭКСПОРТЫН



2.5 САЯ
ТОНН

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО



1.1 ИХ НАЯД
ТӨГРӨГ

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО



283.5 ТЭРБУМ
ТӨГРӨГ

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЦЭВЭР АШИГ



283.5
ТЭРБУМ ТӨГРӨГ



ХУДАЛДАН АВАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- ӨРСӨЛДӨХ ТЭГШ БОЛОМЖТОЙ
- ИЛ ТОД
- ҮР АШИГТАЙ
- ХЭМНЭЛТТЭЙ
- ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ

2023 онд Төрийн худалдан авах ажиллагааны системд нийт 119 нэр төрлийн 416,1 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс 352.7 тэрбум төгрөгийн 35 тендер шал гаруулалтыг зохион байгуулж ажиллав. Хуулийн дагуу шууд худалдан авч болох хангамжийн бараа материалыг аймаг, орон нутгийн аж ахуй нэгж, байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, нөхөрлөл, малчид, хувь иргэдээс 459.6 сая төгрөгийн худалдан авалтыг хийлээ.

ИЛ, ТОД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ /ЦАХИМ СИСТЕМ www.tender.gov.mn/



Монгол улсын Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол, Нүүрс экспортыг цахим системээр зохион байгуулах тухай 466 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газартай ачаа тээврийн Ерөнхий гэрээ байгуулан тээврийн компаниудын сонгон шалгаруулалтыг явуулж 68 тээврийн компанитай гэрээ байгуулан ажиллав.

Нүүрс тээврийн “С” зөвшөөрлийн бичгийг
2023 оны 1-4 дүгээр улиралд нийт **4748** ширхгийг
олгосон.



ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ



ТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ ГЭРЭЭТ АЖ АХУЙ НЭГЖҮҮД

- › Уртын тээврийн ерөнхий гэрээт компани 220км-42
- › Богинын тээврийн ерөнхий гэрээт компани 30км-10
- › Терминалын тээврийн ерөнхий гэрээт компани 8км-16

2023 ОНД НҮҮРС ТЭЭВЭРЛЭХ АЧАА ТЭЭВРИЙН ГЭРЭЭ


- › Богинын тээврийн чиглэлд Ачаа тээврийн 85 гэрээ /Цагаанхад-Ганцмод/
- › Терминалын тээврийн чиглэлд Ачаа тээврийн 40 гэрээ
- › /ЧТТ-Ганцмод/
Уртын тээврийн чиглэлд Ачаа тээврийн 3 гэрээ
- › /Тавантолгой ХК-Цагаанхад/
Гашуун сухайт төмөр зам терминал-Чингэлэг
- › тээврийн терминал чиглэлд Ачаа тээврийн 1 гэрээ
Нийт 129 “Ачаа тээврийн гэрээ”-г байгуулан ажилласан.

ДОТООД ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ



“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 32 тоот тогтоолоор “Дотоод аудитын хэлтэс”, 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот тогтоолоор “Дотоод хяналтын хэлтэс” болон шинэчлэгдсэн.

2023 онд төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 13, ажлын хэсэгт 18 нийт 24 хяналт шалгалт хийж, 69 зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэн ажиллав. Мөн салбарын хяналтын байгууллагын үлгэрчилсэн “Хяналтын хуудас”-ыг компанийн үйл ажиллагааны эрхлэх хүрээ, онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, компанийн газар, хэлтэс, албадын ажлын гүйцэтгэлд нийт 26 төрлийн 60 хяналтын хуудсаар хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой холбогдох зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.





**НҮҮРС ЭКСПОРТЫГ ЦАХИМ БИРЖЭЭР БОРЛУУЛАХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА.**

“ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 23-ний өдөр батлагдаж 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн биржээр 2023 онд олборлогч таван компанийн 14.9 сая тонн нүүрсийг 7.4 их наяд төгрөгөөр арилжаалав. Үүнээс манай компани нийт 5 удаагийн арилжааг Монголын хөрөнгийн биржийн цахим системээр амжилттай зохион байгууллаа.

“ Өнгөрөгч онд нийт 3.2 сая тонн коксжих нүүрсийг цахимаар арилжиж нэг удаагийн арилжаагаар 960 мянган тонн коксжих нүүрсийг тонн тутмын үнэ 158.87 ам доллароос \$173.37 ам долларт хүрч Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн хамгийн өндөр дүнтэй арилжаа болж дээд амжилтыг тогтоосон явдал нь уурхайчдын хувьд томоохон амжилт байлаа.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ





ТАВАН ТОЛГОЙ ХХ



НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ




“ 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 1-ны өдрийг хүртэл хувьцааны ханш 8,200 төгрөгөөс 19,000 төгрөг болж 131.7%-иар буюу 10,800 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх хугацаанд 373,282 ширхэг хувьцааг 4.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2022 оны ногдол ашгийг 2023 онд нийт 291.3 тэрбум төгрөг хуваарилж үүнээс 51 хувь буюу Өмнөговь аймгийн төсөвт 148.6 тэрбум төгрөг, бусад хувьцаа эзэмшигчдэд 142.7 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 2,787.0 төгрөгийг, 2023 оны 07-р сарын 21-ний өдрийн тогтоолоор нэгж хувьцаанд 2,743.8 төгрөг нэмж хуваарилан 2022 оны ногдол ашигт нэгж хувьцаанд нийт 5,530.8 төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулан 291.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 100 хувь тараасан.

2023 оны ногдол ашгийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 03 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 4,996 төгрөгөөр тооцож нийт 263.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлээд байна.



МАНАЙ ХУВЬЦААГ ДЭЛХИЙН 23 ОРНЫ ИРГЭД ЭЗЭМШДЭГ



АНУ Австрали Аргентин Бельги Бразил Герман Итали Ирланд Их Британи Канад Мексик Монгол Нидерланд Орос Польш Солонгос Тунис Хятад Чех Франц Финланд Узбекистан Япон

БАРИМТ БИЧИГ, ЖУРАМ 56



ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны баримт бичиг, дагалдах журмыг үе шаттайгаар шинэчлэн боловсруулав. Мөн 2023 оны “Тавантолгой” ХК-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Өмнөговь аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан.



ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

Үзүүлэлт	Хүний тоо
Яаралтай тусламжийн нэгжээр үйлчлүүлэгсдийн тоо /давхардсан тоогоор/	1,357
Даралт болон зүрхний өөрчлөлтүүдийн хяналт /даралт хэмжилт давхардсан тоогоор/	840
Ажлаас буулгасан	24

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



“Нэн түрүүнд ХАБ-2023” бага хуралд аюулгүй ажиллагааны мэргэжилтнүүд цахимаар оролцсон. Энэхүү бага хурал нь 12 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд ХЭМАБ-ын Манлайлал уриан дор боллоо.

БЭРТЭЛ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ 0.00

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ 11,892 хүн/цаг



ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР
АЛДАЛТГҮЙ

**1543 хоног,
1,612,146
хүн/цаг**

АЮУЛ ОСОЛГҮЙ
АЖИЛЛАЛАА.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР





“ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлаас гадна Өмнөговь аймгийн БОАЖГ-аас хаягдлын овоолго болон шимт хөрсний нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийх ажлыг нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгаж оруулах ажлын дагуу хаягдлын овоолгод нөхөн сэргээлт хийлээ.



ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн сайжруулсан 25 км шороон замын нөхөн сэргээлт Хаягдлын овоолгод 2.3 га талбайн нөхөн сэргээлт хийлээ.



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Шимт хөрсний 1 га талбайд олон наст ургамал тарималжуулаад байна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР



ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Орон нутгийн тусгай хамгаалалттай Цэций ууланд зэрлэг амьтдын идэш тэжээлд нэмэлт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүллээ.

Дүйцүүлэн хамгаалах хуваарьт Цэций ууланд зэрлэг амьтдын тоо толгой, бүртгэлийг хянах зорилгоор автомат камерын тоог нэмэгдүүлэв.

Цогтцэций сумын Сийрст багийн “Элэгний задгай” нэртэй булгийн эхийг хашсан.

Дүйцүүлэн хамгаалах ажлыг оновчтой хэрэгжүүлэхээр “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.



ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД



**“НОГООН ГОВЬ БИД
БҮТЭЭНЭ”** уриан дор нийт
7,5 сая модыг 2020-2030
онд тариалахаар төлөвлөн
ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “НОГООН ГОВЬ БИД БҮТЭЭНЭ” уриан дор нийт 7,5 сая модыг 2020-2030 онд тариалахаар төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд мод үржүүлэг, ойжуулалтын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Булган, Номгон сумдад урт хугацааны төсөл хөтөлбөрийг эхлүүлээд байна.

Өмнөговь аймгийн Ногоон хэрэм төслийн ойжуулсан 50 га талбайд мод үржүүлгийн газар байгуулах ажлыг эхлүүлж Даланзадгад суманд бүс нутгийн онцлогт тохирсон 1,782,294 ширхэг тарьцыг үржүүллээ.





НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ХАМТЫН АЖИЛЛАГАА




Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нийгмийн хариуцлага болон өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хөнгөлөлттэй үнээр нүүрс олгох ажлыг зохион байгуулж 1 тн нүүрсийг 19.500 төгрөг буюу үндсэн үнээс 83 хувиар хямдруулан олголоо.

“ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛЭЭРЭЭ ЭХ НУТАГТАА АЖИЛЛАЦГАА тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж буй оюутан залууст сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, нутагтаа ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүллээ. 2022-2023 оны хичээлийн жилд нийт 55 оюутан тус тэтгэлэгт хамрагдаж, 2020-2023 онд нийт 355 оюутан хамрагдсанаас 219 оюутан амжилттай суралцан төгссөж 172 төгсөгч орон нутагтаа ажиллаж байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Цогтцэций суманд камерын иж бүрэн систем суурилуулах, Цагаан-Овоо, Сийрст, Билгэх, Өгөөмөр багийн нийт малчдад бэлчээр ашиглалт, малчдын амьжиргааг чадавхжуулах, малын таваарлаг чанарыг нэмэгдүүлэх талаар сургалт, уулзалт зохион байгуулж, малчдын дунд бэлчээр ашиглагчдын хоршоо байгуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах, амьжиргааг дээшлүүлэх талаар зөвлөх үйлчилгээ үзүүлж, төрийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“ТАВАНТОЛГОЙ”ХК НЬ “ENTREPRENEUR-2023” ХҮРЭЛ МЕРКУРИ ЦОМЫН ЭЗЭН БОЛЛОО

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас уламжлал болгон зохион байгуулдаг “Оны Шилдэг болон тодорхой салбарын Онцлох аж ахуйн нэгж”-ийг өргөмжлөн алдаршуулдаг “ENTREPRENEUR” 2023 үйл ажиллагаа 26 дахь жилдээ зохион байгуулагдаж, Уул уурхайн салбарын шилдэг “ENTREPRENEUR”, хүрэл меркури цомын эзнээр орон нутгийн өмчит ууган уурхай “Тавантолгой”ХК шалгарлаа.



ОРДЫН НӨӨЦИЙГ ШИНЭЭР ТОГТООХ ХАЙГУУЛЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

2023 онд ашиглалтын үеийн нэмэлт хайгуулын ажлаар 7,000 тууш метр өрөмдлөгийн ажил хийж, тухайн ажлын үр дүн болон өмнөх онуудын хайгуулын ажлын үр дүнгүүдийг нэгтгэн ордын нөөцийн тооцоог шинээр тооцоолохоор зөвлөх үйлчилгээний компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.





ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ ТӨМӨР ЗАМЫН АНХНЫ ТЭЭВРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

“Тавантолгой төмөр зам” ХХК-тай “Төмөр замаар нүүрс тээвэрлэх гэрээ”-г байгуулсны дагуу 2023 оны 4-р сарын 5-ны өдөр анхны тээврийг эхлүүлж, 22 вагон 44 чингэлэг бүхий нийт 1395 тонн нүүрсийг Тавантолгой өртөөнөөс Гашуун сухайт өртөө чиглэлд тээвэрлэж, компанийн түүхэнд нэгэн шинэ хуудсыг эхлүүлээ.



НҮҮРС ТЭЭВРИЙН 9,2 КМ ШОРООН ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Уурхайн хөрсний овоолгын талбай, нүүрс экспортлох тээврийн замгүй болох эрсдэл үүссэнийг цаг алдалгүй шийдвэрлэн, нүүрс тээврийн 9.2 км шороон замыг туслан гүйцэтгэгч компаниудын техник, хүн хүчээр ажлын хөлс тооцолгүй гүйцэтгүүлснээр 1.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргалаа.



“

ШИНЭЭР 60 ТАЛБАЙД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХИЙЖ ЗАСВАРЫН ШОПЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Гаалийн хяналтын бүсийн зориулалтаар ашиглах 60 га талбайг бүрэн ашиглалтад оруулж Уурхай дахь засварын газар, оффис, лабораторийн зориулалттай барилгын ажлыг 2023 оны 07 сард эхлүүлж 2023 оны 11 сард ашиглалтад хүлээн аваад байна.



“

НҮҮРС АЧИЛТ БУУЛГАЛТЫН ТАЛБАЙД АВТО ПҮҮ, ХУЧЛАГЫН ТАВЦАН БАЙГУУЛЛАА

Уурхайн ачилтын талбайд шинээр 200 тн-ын даацтай 3ш авто жин байгуулах ажлыг тендер шалгаруулалтын дагуу гүйцэтгэж, суурийн ажлыг өөрсдийн хүн хүч, техник тоног төхөөрөмжөөр хийлээ. Мөн нүүрс тээвэрлэлтийн хучлагын тавцан байгуулах зураг гарган тендер зарлан шалгаруулж төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэв.

📍 Тавантолгой ХК Төлөөлөгчийн газар,
Даланзадгад зочид буудал 202 тоот,
Даланзадгад сум,
Өмнөговь аймаг
☎ (976) 8802-6346, 7053-2550

📍 Тавантолгой Хувьцаат компани,
Цагаан-Овоо баг, Цогтцэций сум,
Өмнөговь аймаг
☎ (976) 7535-5555, 9500-1619

✉ info@tavantolgoi.mn
🌐 www.tavantolgoi.mn
📘 www.facebook.com/TavantolgoiJSC

ТАВАНТОЛГОЙ ХК
2024 ОН